



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/286

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, 59 дүгээр зүйлийн 59.10.1, 59.10.2, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 15 дугаар дүгнэлтийн дагуу БОАЖЯ/20240101011/01/01 урилгын дугаартай Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга (Өвөрхангай, Арвайхээр сум) ажлыг 2,502,623,390 (хоёр тэрбум таван зуун хоёр сая зургаан зуун хорин гурван мянга гурван зуун ер) төгрөгөөр Ариун билгүүн ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0588

D:My Doc. Zahiramj. Zasag darga